



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 19 өдөр

Дугаар А/400

Хэрлэн сум

“Монголын мастеруудын спортын VI”
наадамд оролцоход дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Ахмадын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төр-Иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор Монголын мастеруудын биеийн тамир спортын Хэнтий аймгийн салбар хороо “Монголын мастеруудын спортын VI” наадамд оролцох зардалд зориулж 3,000,000 (гурван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний “Төр-Иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх” зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022
оны 18 дугаар сарын 19-ны
А/А/ захирамжийн хавсралт

Шаардагдах зардлын тооцоо

№	Зардлын нэр	Тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	"Монголын мастеруудын спортын VI" наадамд оролцох зардал	1	3,000,000	3,000,000
Нийт				3,000,000